

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Орон нутгийг судлах музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/30/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 99177546 Аудитор: Б.Цэвэлмаа Утас: 99026016	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn Цахим хаяг: Tsevelmaab@audit.gov.mn
---	---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Залруулсан алдаа	13
4.2 Төлбөрийн акт.....	13
4.3 Албан шаардлага	13
4.4 Зөвлөмж.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙГ СУДЛАХ МУЗЕЙН
ЗАХИРАЛ Ц.ОЮУНЗУЛ ТАНАА

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022. 02. 25 № 66

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Орон нутгийн судлах музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Говь-Алтай Говь-Алтай аймгийн Орон нутгийн судлах музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлалгүй тавилга бэлтгэсэн, татварын тодорхойлолтоор илүү, дутуу төлөлт татварын цахим системд бүртгэлтэй зэрэг 15.5 сая төгрөгийн зөрчлүүд нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

117000357

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	20,108,074.00	25,527,644.78
33	АВЛАГА	0.00	121,260.78
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	121,260.78
35	БАРАА МАТЕРИАЛ	20,108,074.00	25,406,384.00
35100	Түүхий эд материал	10,892,260.00	14,445,550.00
35110	Тусгай зориулалттай материал	10,892,260.00	14,445,550.00
35400	Хангамжийн материал	9,215,814.00	10,960,834.00
35410	Бичиг хэргийн материал	2,218,275.00	1,477,475.00
35420	Аж ахуйн материал	5,488,639.00	7,111,339.00
35440	Түлш, шатах тослох материал	358,000.00	455,020.00
35450	Барилгын засварын материал	119,000.00	204,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,031,900.00	1,713,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,039,020,296.03	1,048,362,587.75
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,039,020,296.03	1,048,362,587.75
39200	Биет хөрөнгө	1,007,905,296.03	1,017,338,587.75
39201	Барилга, байгууламж, орон сууц	243,988,737.45	243,988,737.45
39202	Хуримтлагдсан элэгдэл	-199,534,677.45	-202,339,270.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	27,000,000.00	27,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-27,000,000.00	-27,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	77,867,309.75	93,033,109.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	-63,144,007.70	-67,201,240.97
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	87,280,877.00	96,280,877.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-38,369,943.02	-46,240,624.68
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	899,078,000.00	899,078,000.00
39217	Ном	739,000.00	739,000.00
39300	Биет бус хөрөнгө	31,115,000.00	31,024,000.00
39301	Програм хангамж	540,000.00	540,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-305,000.00	-396,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	30,880,000.00	30,880,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,059,128,370.03	1,073,890,232.53
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,059,128,370.03	1,073,890,232.53
51	Засгийн газрын хувь оролцоо	1,059,128,370.03	1,073,890,232.53
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	150,116,629.00	150,116,629.00
51200	Хуримтлагдсан үр дүн	-27,615,477.37	-12,853,614.87
51210	Өмнөх үеийн үр дүн	-28,329,766.22	-27,615,477.37
51220	Тайлант үеийн үр дүн	714,288.85	14,761,862.50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	936,627,218.40	936,627,218.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,059,128,370.03	1,073,890,232.53

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	299,873,200.00	301,163,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	1,955,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	1,955,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	1,955,800.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	1,955,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	299,873,200.00	299,207,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,965,500.00	713,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,965,500.00	713,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	296,907,700.00	298,494,900.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	296,907,700.00	298,494,900.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	299,158,911.15	286,401,837.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	299,158,911.15	286,401,837.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	279,488,942.15	280,966,454.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	159,240,115.00	164,733,149.00
210101	Үндсэн цалин	139,740,115.00	145,833,149.00
210105	Гэрээт ажлын хөлс	19,500,000.00	18,900,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,382,591.00	18,955,778.02
210201	Тэтгэврийн даатгал	11,876,102.00	13,122,453.02
210202	Тэтгэмжийн даатгал	1,397,188.00	1,458,331.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,117,751.00	1,166,665.00
210204	Ажилгүйдлийн даатгал	273,893.00	291,666.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,717,657.00	2,916,663.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,828,425.00	41,546,583.00
210301	Гэрэл, цахилгаан	2,400,253.00	2,885,179.00
210302	Түлш, халаалт	34,689,600.00	38,015,000.00
210303	Цэвэр, бохир ус	738,572.00	646,404.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,020,131.00	13,940,556.00
210401	Бичиг хэрэг	4,647,900.00	4,228,400.00
210402	Тээвэр, шатахуун	4,781,101.00	3,178,872.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,273,930.00	1,344,874.00
210404	Ном, хэвлэл	4,225,870.00	86,710.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,091,330.00	5,101,700.00
2105	Нормативт зардал	940,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	940,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,932,900.00	19,463,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	994,000.00	75,000.00
210604	Урсгал засвар	7,938,900.00	19,388,200.00
2107	Томилолт, зочны зардал	4,857,900.00	4,647,600.00
210702	Дотоод албан томилолт	4,857,900.00	4,647,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,678,800.00	1,123,580.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	878,800.00	1,123,580.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	800,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,608,080.15	16,556,008.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,354,580.00	857,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,400,000.00	875,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,853,500.15	14,823,508.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,669,969.00	5,435,383.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,130,200.00	4,913,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,130,200.00	4,913,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,539,769.00	522,383.20
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,539,769.00	522,383.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	714,288.85	14,761,862.50
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	714,288.85	14,761,862.50

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-	150,116,629.00	936,627,218.40	-28,329,766.22	1,058,414,081.18

	нээрх үлдэгдэл				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	150,116,629.00	936,627,218.40	-28,329,766.22	1,058,414,081.18
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	714,288.85	714,288.85
10	2020 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	150,116,629.00	936,627,218.40	-27,615,477.37	1,059,128,370.03
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	150,116,629.00	936,627,218.40	-27,615,477.37	1,059,128,370.03
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	150,116,629.00	936,627,218.40	-27,615,477.37	1,059,128,370.03
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	14,761,862.50	14,761,862.50
20	2021 оны 12-р сарын 31- наарх үлдэгдэл	150,116,629.00	936,627,218.40	-12,853,614.87	1,073,890,232.53

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	299,873,200.00	299,207,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	299,873,200.00	299,207,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,965,500.00	713,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,965,500.00	713,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	296,907,700.00	298,494,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	296,907,700.00	298,494,900.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	281,420,901.00	276,997,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	281,420,901.00	276,997,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	261,750,932.00	271,562,516.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	159,240,115.00	164,722,216.80
210101	Үндсэн цалин	139,740,115.00	145,822,216.80
210105	Гэрээт ажлын хөлс	19,500,000.00	18,900,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,382,591.00	19,087,971.00
210201	Тэтгэврийн даатгал	11,876,102.00	13,254,645.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,397,188.00	1,458,331.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,117,751.00	1,166,665.00
210204	Ажилгүйдлийн даатгал	566,149.00	291,666.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,425,401.00	2,916,664.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,828,425.00	41,546,583.00
210301	Гэрэл, цахилгаан	2,400,253.00	2,885,179.00
210302	Түлш, халаалт	34,689,600.00	38,015,000.00
210303	Цэвэр, бохир ус	738,572.00	646,404.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,924,521.00	16,140,866.00
210401	Бичиг хэрэг	6,142,700.00	3,443,100.00
210402	Тээвэр, шатахуун	5,139,101.00	3,275,892.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,273,930.00	1,344,874.00
210404	Ном, хэвлэл	3,961,000.00	2,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,407,790.00	6,077,000.00
2105	Нормативт зардал	940,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	940,000.00	0.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,144,000.00	21,078,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	994,000.00	1,214,000.00
210604	Урсгал засвар	9,150,000.00	19,864,700.00
2107	Томилолт, зочны зардал	4,857,900.00	4,647,600.00
210702	Дотоод албан томилолт	4,857,900.00	4,647,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,678,800.00	1,123,580.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	878,800.00	1,123,580.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	800,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,754,580.00	3,215,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,354,580.00	1,365,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,400,000.00	1,850,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,669,969.00	5,435,383.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,130,200.00	4,913,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,130,200.00	4,913,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,539,769.00	522,383.20
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,539,769.00	522,383.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	18,452,299.00	22,210,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	18,452,299.00	22,210,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,452,299.00	22,210,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	18,452,299.00	22,210,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	18,452,299.00	22,210,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-18,452,299.00	-22,210,000.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	Цэвэр гүйцэтгэл	Төсвийн хэмнэлт+, хэмнэлт-	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	298,494,900.0	297,972,516.80	522,383.20	100%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	298,494,900.0	297,972,516.8	522,383.2	100%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	294,294,900.0	293,772,516.80	522,383.2	100%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	164,732,900.0	164,722,216.80	10,683.2	100%
210101	Үндсэн цалин	145,232,900.0	145,822,216.80	(589,316.8)	100%
210105	Гэрээт ажлын хөлс	19,500,000.0	18,900,000.00	600,000.0	97%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,280,100.0	19,087,971.00	192,129.0	99%
210201	Тэтгэврийн даатгал	12,794,000.0	13,254,645.00	(460,645.0)	104%
210202	Тэтгэмжийн даатгал	1,621,500.0	1,458,331.00	163,169.0	90%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,297,200.0	1,166,665.00	130,535.0	90%
210204	Ажилгүйдлийн даатгал	324,300.0	291,666.00	32,634.0	90%
210205	Эрүүл мэндийн даатгал	3,243,100.0	2,916,664.00	326,436.0	90%

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,785,000.0	41,546,583.00	238,417.0	99%
210301	Гэрэл, цахилгаан	3,030,000.0	2,885,179.00	144,821.0	95%
210302	Түлш, халаалт	38,015,000.0	38,015,000.00	-	100%
210303	Цэвэр, бохир ус	740,000.0	646,404.00	93,596.0	87%
2104	Хангамж, бараа материалын зардал	16,143,400.0	16,140,866.00	2,534.0	100%
210401	Бичиг хэрэг	3,443,800.0	3,443,100.00	700.0	100%
210402	Тээвэр, шатахуун	2,942,000.0	3,275,892.00	(333,892.0)	111%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,680,600.0	1,344,874.00	335,726.0	80%
210404	Ном, хэвлэл	2,000,000.0	2,000,000.00	-	100%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,077,000.0	6,077,000.00	-	100%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,290,000.0	43,288,700.00	1,300.0	100%
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,425,000.0	14,424,000.00	1,000.0	100%
210602	Тавилга	9,000,000.0	9,000,000.00	-	100%
210604	Урсгал засвар	19,865,000.0	19,864,700.00	300.0	100%
2107	Томилолт, зочны зардал	4,698,000.0	4,647,600.00	50,400.0	99%
210702	Дотоод албан томилолт	4,698,000.0	4,647,600.00	50,400.0	99%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,150,000.0	1,123,580.00	26,420.0	98%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,150,000.0	1,123,580.00	26,420.0	98%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,215,500.0	3,215,000.00	500.0	100%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,365,000.0	1,365,000.00	-	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,850,500.0	1,850,000.00	500.0	100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,200,000.00	4,200,000.00	-	100%
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,200,000.0	4,200,000.00	-	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,200,000.0	4,200,000.00	-	100%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	298,494,900.0	297,972,516.80	522,383.2	100%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	298,494,900.0	297,972,516.80	522,383.2	100%
132001	Орон нутгийн төсвөөс	298,494,900.0	297,972,516.80	522,383.2	100%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	713,000.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	713,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	713,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	713,000.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		713,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	713,000.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	713,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	713,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орон нутгийг судлах музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэвэлмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Орон нутгийг судлах музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 4 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говь-Алтай аймгийн Орон нутгийг судлах музей нь соёлын үнэт зүйлийг эрэн сурвалжлах, нээж илрүүлэх, олж авах, боловсрол, танин мэдэхүйн ажил зохион байгуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, үр дүнг хэвлүүлэх, түгээх зэрэг чиг үүрэгтэй аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй харин Монгол Улсын Засгийн газрын 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахаар даалгасан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орон нутгийг судлах музейн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 299.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 6.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4.8 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-ын 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орон нутгийг судлах музейн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1 хувиар буюу 14.8 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна.

Авлага дансны үлдэгдэл 0.1 сая төгрөг нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 25.4 сая төгрөг болж 5.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 32.0 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 26.7 сая төгрөгийн материалыг зарцуулсантай холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,391.5 сая төгрөг болж 24.1 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 22.2 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 2.0 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,073.9 сая төгрөг болж 14.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 1 хувиар буюу 1.3 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлоготой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл -12.8 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 570.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 271.6 сая төгрөгөөр бууруулж, 298.5 сая төгрөгөөр баталжээ. Батлагдсан төсөв төсвийн төслөөс бага байгаа нь цалингийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг бууруулж баталсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 2 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 298.5 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 298.5 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 298.0 сая төгрөгийг зарцуулж 0.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 298.0 сая төгрөг буюу 99 хувьтай байгаа нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 0.2 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.2 сая төгрөгөөр, томилолт зочны зардлыг 0.1 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 0.7 сая төгрөгийн орлого хүлээн авч, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, худалдан авалтын и-баримтыг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 145 мэдээллийг хугацаандаа, 4 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд 3.6 сая төгрөгийн худалдан авалтын и-баримтыг дутуу шивүүлснийг аудитын явцад залруулсан.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, Татварын ерөнхий хуулийн 28., 2-т " Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3 дахь заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1.1 сая төгрөгийн төлбөрийн акт, 1.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн жилийн аудитаар түлш халаалтын өглөг, төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 19.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4.4 сая төгрөгийн алдааг залруулж, 0.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 15.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Нэмэлт санхүүжилтийн орлогыг 0.7 сая төгрөгөөр, үр дүнгийн тайланг 0.1 төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг аудитын явцад байгууллагын удирдлага, нягтлан бодогч хүлээн зөвшөөрч санхүүгийн тайланд залруулав. Мөн 3.6 сая төгрөгийн худалдан авалтын и-баримтыг гаргуулаагүй байсныг аудитын явцад нөхөж шивүүлсэн.

4.2 Төлбөрийн акт

Албан хаагчид 0.4 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг дутуу бодож олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам", Соёлын хэлтсийн даргын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 3 дугаар тушаалыг зөрчсөн, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

Хөндлөнгийн мэдээлэлтэй тулган баталгаажуулахад 1.2 сая төгрөгийн түлш халаалтын өглөгтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг

зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасныг зөрчсөн, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлалгүй 9.0 сая төгрөгийн тавилга бэлтгэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.5-д "автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 0.4 сая төгрөгийн дутуу, 4.5 сая төгрөгийн илүү төлөлт татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" гэж заасныг зөрчсөн, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгсөн алдаа зөрчилтэй асуудал байхгүй.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говь-Алтай аймгийн Орон нутгийг судлах музей	6	19.9	2	4.4	1	0.4	3	15.1	0	0

/сая төгрөгөөр/